


2015 оны 06 дугаар сард Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын мэдээ

Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2015 оны эхний 6 сард иргэд, байгууллагаас 4889 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 116 нэгж буюу 2.4 хувиар өссөн байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 299 буюу 6.1 хувь нь санал, 4509 буюу 92.2 хувь нь өргөдөл, 81 буюу 1.7 хувь нь гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдол



Өргөдөл, гомдлыг
үтгээр нь авч үзвэл: 719 буюу 14.7 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 185 буюу 3.8 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1030 буюу 21.0 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1337 буюу 27.3 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 216 буюу 4.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 1402 буюу 28.7 хувь нь бусад өргөдөл гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 4872 буюу 99.6 хувийг шийдвэрлэж, 17 өргөдлийн үлдэгдэлтэй байна.





Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар




2015 оны эхний хагас жилд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 884 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 506 нэгж буюу 57.2 хувиар өссөн байна.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 35 буюу 4.0 хувь санал, 821 буюу 92.8 хувь нь өргөдөл, 28 буюу 3.2 хувь нь гомдол байна.





Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 154 буюу 17.4 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 33 буюу 3.7 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 154 буюу 17.4 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 220 буюу 24.9 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 30 буюу 3.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 293 буюу 33.1 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төв ирсэн өргөдөл, гомдол, шүүмлэл, санал хүсэлтийн талаар


2015 оны эхний 6 сарын байдлаар иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 210 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 78 буюу 37.1 хувь нь санал хүсэлт, 86 буюу 41.0 хувь нь гомдол, 35 буюу 17.0 хувь нь талархал, 9 буюу 4.3 хувь нь шүүмжлэл, 2 буюу 1.0 хувь нь өргөдөл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 204 буюу 97.1 хувийг шийдвэрлэж, 6 буюу 2.9 хувь нь ажиллагаанд байна.

Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2015 оны эхний 6 сард иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 910 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 327 нэгж буюу 56.0 хувиар өсч, 941 алба хаагч холбогдсоны 695 буюу 73.8 хувь нь офицер, 234 буюу 25.0 хувь нь ахлагч, 12 буюу 1.3 хувь нь энгийн алба хаагчид байна. Нийт өргөдөл гомдлын 833 буюу 91.5 хувийг барагдуулж, 77 буюу 8.5 хувийн үлдэгдэлтэй байна.



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС